



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ
ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН
ТАНХИМ



ТӨР,
ХУВИЙН ХЭВШЛИЙН
ТҮНШЛЭЛИЙН ТӨВ

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ, ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ ТӨВ ХООРОНДЫН ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ

2025 оны 03 дугаар сарын 17 өдөр

Дугаар 0025/01

Улаанбаатар хот

Энэхүү Хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг /цаашид “Санамж бичиг” гэх/-ийг нэг талаас Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим, түүнийг төлөөлж Ерөнхийлөгч Л.Төр-од /цаашид “МҮХАҮТ” гэх/ нөгөө талаас “Төр хувийн хэвшлийн түншлэл төв” ТӨААТҮГ, түүнийг төлөөлж Газрын захирал М.Амгаланбаатар /цаашид “ТХХТТ” гэх/, бид /цаашид тусад нь “Тал”, хамтад нь “Талууд” гэх/ хооронд хоёр байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор харилцан тохиролцож энэхүү “Санамж бичиг”-ийг байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Санамж бичгийн зорилго нь МҮХАҮТ болон ТХХТТ-ийн хамтын ажиллагааны эхлэлийг тавихад оршино.
- 1.2 Санамж бичиг нь Талуудын дагаж мөрдөж буй аливаа дүрэм, журамд нийцсэн бөгөөд санамж бичиг байгуулах болсон үндэслэл, шалтгаан нөхцлийн талаар талууд бүрэн ойлголцсон болно.
- 1.3 Талууд хамтын ажиллагаандаа хууль дээдлэх, хоорондын харилцааны зохистой хэм хэмжээг баримтлан харилцан санал солилцох, зөвшилцөх, эрх тэгш байдлыг эрхэмлэн, нээлттэй, ил тод байх, үр бүтээлтэй хамтран ажиллах зарчмуудыг баримтална.
- 1.4 Энэхүү санамж бичиг нь Талууд цаашдын харилцаандаа дагаж мөрдвөл зохих үндсэн баримт бичиг болох бөгөөд хууль эрх зүйн болон санхүүгийн аливаа үүрэг, хариуцлага хүлээхгүй болно.

ХОЁР.ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

2.1. Санамж бичгийн хүрээнд дараах чиглэлээр хамтран ажиллана. Үүнд:

- 2.1.1. Талууд Хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, бизнесийн орчинд тулгарч буй бэрхшээлийг арилгахад төр, хувийн хэвшлийнхэн харилцан ярилцаж ойлголцох улмаар хамтран ажиллах механизмыг хөгжүүлэх, хувийн хэвшлийн салбарыг бэхжүүлэх чиглэлээр идэвхи санаачлагатай ажиллах;
- 2.1.2. Талууд бизнесийн хууль эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор хамтын хүчин чармайлтаар төрийн бодлого, шийдвэрт санал, зөвлөмжийг боловсруулахад бизнес эрхлэгчдийн саналыг тусгахад дэмжлэг үзүүлэх;

- 2.1.3. Талууд хоёр байгууллагын харилцан хамтын үйл ажиллагааг харилцан дэмжиж, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль тогтоомжийг бизнес эрхлэгч, олон нийтэд хүргэх, таниулах, сурталчлах ажлыг хамтран зохион байгуулах;
- 2.1.4. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх чиглэлээр төрийн байгууллага, бизнес эрхлэгчдийн төлөөллийг оролцуулсан уулзалт, хэлэлцүүлгийг хамтран зохион байгуулах, уулзалтаас гарсан саналыг холбогдох төрийн байгууллагуудад уламжлах;
- 2.1.5. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн зөвлөл байгуулж ажиллах, цаашдын ажлаа өргөжүүлэх чиглэлээр МҮХАҮТ болон ТХХТТ удирдлагын түвшин дэх уулзалтыг хагас жил тутам зохион байгуулах;
- 2.1.6. Талууд өөр, өөрсдийн зохион байгуулж буй арга хэмжээ, уулзалт, зөвлөгөөн, семинар, сургалт нөгөө Талын оролцох оролцоог нэмэгдүүлэх, дэмжих арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- 2.1.7. Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх хороог орон нутагт байгуулах, үр дүнтэй ажиллуулахад орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын санаачлага оролцоог хангах, чиглэл өгөх, энэ чиглэлээр МҮХАҮТ-ын Салбар танхимуудтай хамтран ажиллах.

2.2. Талууд санамж бичгийн хүрээнд харилцан тохиролцсоны үндсэн дээр үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хариуцах нэгж, ажилтнуудыг томилон ажиллуулах ба хэрэгжилтийг жил тутам дүгнэнэ.

ГУРАВ. БУСАД

- 3.1. Энэхүү Санамж бичиг нь талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох бөгөөд 3 /гурав/ жилийн хугацаанд хүчинтэй байна.
- 3.2. Талууд Санамж бичигт харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Санамж бичгийн адил хүчин төгөлдөр байна.
- 3.3. Санамж бичгийн хүрээнд харилцан солилцсон мэдээллийг зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд задруулахгүй байна.
- 3.4. Талууд энэхүү Санамж бичгийг хэрэгжүүлэх хүрээнд үүсэж болох аливаа маргааныг харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ.

Энэхүү санамж бичгийг 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Улаанбаатар хотноо хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна.

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ
ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН
ТАНХИМЫГ ТӨЛӨӨЛЖ

ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН
ТҮНШЛЭЛИЙН ТӨВ ТӨААТУГ-ЫГ
ТӨЛӨӨЛЖ

ЕРӨНХИЙЛӨГЧ Л.ТӨР-ОД



ЗАХИРАЛ М.АМГАЛАНБААТАР

